



ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2024 оны 05 сарын 10 өдөр

Дугаар

A/251

Хэрлэн сум

Арга хэмжээг зохион байгуулж,  
хяналт тавих ажилд хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1. Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3. Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.3, 32.1.10 дахь заалт, Улсын онцгой комиссын даргын 2023 оны 8 дугаар тушаал, аймгийн Онцгой комиссын 11 дүгээр хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Өвөлжилт, хаваржилтыг даван туулах, аймаг, сумын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах зорилгоор байгуулагдсан аймгийн шуурхай штабын үйл ажиллагааны бэлэн байдлыг хангах, зүй бусаар хорогдсон мал, амьтны сэг зэмийг устгалын ажлыг эрчимжүүлж, орчны халдваргүйтгэлийн арга хэмжээг зохион байгуулж, хяналт тавих ажилд 28,000,000 (хорин найман сая) төгрөгийн хөрөнгө зарцуулсугай.

2.Зарцуулах хөрөнгийн зардлын тооцоог хавсралтаар баталсугай.

3.Зүй бусаар хорогдсон мал, амьтны сэг зэм устгаж ариутгал халдваргүйтгэлийн ажлыг чанартай зохион байгуулж ажиллахыг Онцгой байдлын газрын дарга, хурандаа (Ж.Эрдэнэбат)-д даалгасугай.

4.Дээрх зардалд шаардагдах хөрөнгийг аймгийн эрсдэлийг бууруулах сангаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (С.Нямдаваа)-д, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Л.Батсайхан)-д нарт тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ



Аймгийн Засаг даргын 2024 оны  
дугаар сарын...-ны өдрийн  
дугаар захирамжийн хавсралт

### ЗАРДЛЫН ТООЦОО

Д/д	Зардлын төрөл	Мөнгөн дүн
1	Галшар сум сэг зэм устгалын ажилд	24.718.600
2	Сэг зэм устгалын ажилд дайчилгаагаар ажилласан "Хэнтий ус" ХХК-ны Хово автомашины 2 ш дугуйны зардалд	1.880.000
3	Сэг зэм устгалын явцтай танилцах, мэргэжлийн удирдлагаар хангах ажлын хэсгийн шатахууны зардалд	1.416.000
Нийт		28.000.000